



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгалын зуучлагч “Ковер хилл” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг хавсралтын дагуу бүртгэсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Ковер хилл” ХХК /Г.Энхтайван/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохиулах хорооны  
2020 оны 07 дүгээр сарын 22-ны өдрийн  
19/1 дүгээр тогтоолын хавсралт

“КОВЕР ХИЛЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

/төгрөгөөр/

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Гаргасан хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 35 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Гаргасан хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Гаргасан хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 35 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Г.Энхтайван /ШБ86060971/	1,970,000	68,950,000.00	97.52%	-	-	-	1,970,000	68,950,000.00	81.237%
2	М.Олдохбаяр /ЧС86031271/	50,000	1,750,000.00	2.48%	-	-	-	50,000	1,750,000.00	2.062%
3	Т.Чулуунхүү /УХ59082514/	-	-	-	196,000	6,860,000.00	-	196,000	6,860,000.00	8.082%
4	Ш.Ганбат /ЖН87090172/	-	-	-	84,000	2,940,000.00	-	84,000	2,940,000.00	3.464%
5	Б.Баясал /ЧК76030271/	-	-	-	125,000	4,375,000.00	-	125,000	4,375,000.00	5.155%
	Нийт	2,020,000	70,700,000.00	100%	405,000	14,175,000.00	-	2,425,000	84,875,000.00	100%